



ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Дорноговь аймгийн
нийгэм, эдийн засгийн
танилцуулга

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2020/04



Мэдээллийн нэгдсэн лавлах: WWW.1212.MN

ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1-14
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	15
Нэг. Эрүүл мэнд.....	16-17
Хоёр. Хөдөлмөр эрхлэлт	18-20
Гурав. Нийгмийн даатгал, халамж.....	21-24
Дөрөв. Гэмт хэрэг.....	25-26
Тав. Мөнгө,зээл	27
Зургаа. Төсөв, санхүү	28-29
Долоо. Үнэ.....	30-33
Найм. Хөдөө аж ахуй	34-36
Ес. Аж үйлдвэр.....	37-41
Арав. Байгаль орчин.....	42

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2020 оны 04 дүгээр сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2020 оны 04 сард 481 эх амаржиж, 481 хүүхэд шинээр мэндэлж, 114 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 57(13.5%)-оор, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 60(14.3%)-аар тус тус өсч, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 23(16.8%)-аар буурсан байна.

Хүн амын цэвэр өсөлт 367 болж 2019 оны мөн үеийнхээс 83(29.2%)-аар өссөн байна. 1000 хүнд ногдох төрөлт 6.8, нас баралт 1.6 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.7 пунктээр өсч, нас баралт өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр буурсан байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2017-2020 оны 04 сард



Он гарсаар нялхсын эндэгдэл 7 байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.5 дахин өсчээ.



1.2 Эрүүл мэнд

2020 оны 04 сарын байдлаар 138.1 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар, 6.4 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 10.3 хувиар, 4.0 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар тус тус өсчээ.




2020 оны 04 сард 628 эх жирэмсний хяналтанд орсны 91.6 хувь буюу 575 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 3.3 пунктээр өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 7.4 мянган удаа гарсны 1.4 мянга буюу 18.9 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар, алсын дуудлага өмнөх оны мөн үеэс 27.3 хувиар тус тус өссөн байна.

Он гарсаар ослын улмаас 864 хүн бэртэж, 17 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 13(1.5%)-аар өсч, нас барсан хүний тоо 11(39.3%)-аар буурсан байна.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2020 оны 04 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд бусад төрлийн өвчин 27.2 хувь, хавдар 25.4 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 20.2 хувь, осол, гэмтэл хордлого гадны шалтгаант үхэл өвчин 14.9 хувь, хоол шингээх эрхтний өвчин 12.3 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 259 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 21-ээр буюу 7.5 хувиар буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад сүрьеэ 18.2 хувиар, тэмбүү 32.7 хувиар, трихоминиаз 24.4 хувиар, цусан суулга 7.7 хувиар, бусад төрлийн өвчин 9.5 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.




1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны 04 сарын эцэст 436 болсны 371(85.1%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 65 (14.9%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 237(64.8%) хүнээр буурч, өмнөх сараас 188(56.9%) хүнээр өсчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 203(46.6%) нь бүрэн дунд, 118(27.1%) нь дээд, 45(10.3%) нь тусгай дунд, 35(8.0%) нь бүрэн бус дунд, 27(6.2%) нь техник мэргэжлийн, 5(1.1%) боловсролгүй, 1(0.2%) магистр, докторын боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2020 оны 04 сарын эцэст



Хөдөлмөрийн хэлтэст 2020 оны эхний 4 сарын байдлаар 40 иргэн шинэ ажлын байранд орж, бүртгэлтэй байсан 68 иргэн ажилд зуучлагдан орж, өмнөх сарын бүртгэлээс 24 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар хасагдсан байна.




1.4 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны 04 сарын байдлаар 14142.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1344.0 (10.5%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны 04 сард өмнөх оны мөн үеэс 1344.0 сая төгрөгөөр нэмэгдэхэд эрүүл мэндийн даатгал 1028.6 (78.7%), тэтгэврийн даатгал 221.0 (2.5%) сая төгрөг,




ҮОМШӨ-ний даатгал 48.6 (3.4%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 26.4 (2.7%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгал 19.4 (4.9%) сая төгрөгөөр өссөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2020 оны 04 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 19398.2 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 3709.9(23.6%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 14305.3 (73.7%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 2405.2 (12.4%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 1275.0 (6.6%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 889.4 (4.6%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 523.3 (2.7%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг






Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2020 оны 04 сард нийгмийн халамжийн сангаас 18919 иргэнд 2840.0 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 499(2.6%)-аар, олгосон тэтгэвэр тэтгэмж 15.5(0.5%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2020 оны 04 сард 1301 хүн хамрагдсан нь өмнөх оноос 45(3.6%)-аар, олгосон тэтгэвэрийн хэмжээ 132.2(16.5%) сая төгрөгөөр тус тус өсчээ.


Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжийг 1046 иргэнд 355.6 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 753 иргэнд 211.5 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 4931 иргэнийг хамруулж, 267.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 10888 иргэн хамрагдаж, 1072.6 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/






1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2020 оны 04 дугаар сарын байдлаар 140 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 31 хүн гэмтэж, 2 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 65(31.7%)-аар, гэмтсэн хүний тоо 37(54.4%) -оор, нас барсан хүний тоо 14(87.8%)-өөр тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийтийн ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 1(33.3%)-ээр, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 3(42.9%)-аар, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 3(4.0%)-аар тус тус өсч, хүн амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 11(91.7%)-ээр, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 10 (66.7%)-аар, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 39(65.0%)-өөр, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 6(54.5%)-аар, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 1(50.0%)-ээр, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 2(15.4 %) -оор тус тус буурч, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 55.7 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 15.0 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 7.9 хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг, 7.1 хувийг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, 3.6 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 3.6 хувийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 7.1 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Сogтуугаар үйлдсэн гэмт хэрэг 21 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21(50.0%)-ээр буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Мандах, Өргөн сумдад нэмэгдэж, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 314.4 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1107.7 (77.9%) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 161.3(51.3%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 35(25.0%) нь гэр орон сууцандаа, 17(12.1%) нь гудамж олон нийтийн газарт, 21(15.0%) нь согтуугаар, 20(14.3%) бүлэглэн, 14(10.0%) хувийг эмэгтэй хүн оролцон, 47(33.6%) нь өдрийн цагаар /14-19 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 357 хүн саатуулагдаж, 58 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2020 оны 04 сард




Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




2.1 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 32.2 мянга болж өмнөх оноос 1.6(4.7%) мянган хүнээр буурч, нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо 65.6 мянга болж өмнөх оны мөн үеээс 7.9 хувиар буурсан байна.

Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2019-2020 он, сая.төг



Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2019- 2020 он, мян.хүн




Нийт хадгаламжийн үлдэгдэл 118.8 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1811.6 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1707.5 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.3(5.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл сарын эцэст 9.5 тэр бум төгрөг болж, өмнөх сараас 1.1(13.4%) тэрбум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 4.9(2.1²) тэр бум төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.8 хувийг эзэлж, өмнөх сараас 0.7 пунктээр өсч, өмнөх оны мөн үеэс 2.2 пунктээр өсчээ.


Чанаргүй зээл сарын эцэст 8451.3 сая төгрөг болж өмнөх сараас 354.5(4.4%) сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1925.0(29.5%) сая төгрөгөөр тус тус өссөн байна. Чанаргүй

зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.1 пунктээр өссөн байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2020.04 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2020.4 сард



2.2 Төсөв, санхүү

2020 оны 04 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 11866.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 66.7 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 56.6 хувиар буурсан байна / 2020 оны орон нутгийн төсвийн орлогод улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын шилжүүлсэн орлогын дүн тусгагдаагүй/. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 73.0 хувийг татварын, 27.0 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2020 оны 04 сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 4183.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 3.5 дахин 2996.5 сая.төг-өөр, төлөвлөгөөнөөс 11.6 хувь буюу 436.2 сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ


Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2020 оны 04 дугаар сарыг өмнөх сартай харьцуулахад 0.3 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар өсчээ.


Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 0.3 хувиар буурахад: орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.5 хувь, тээврийн бүлэг 4.7 хувь, хувцас бөс бараа, бусад бараа үйлчилгээний бүлэг 1.4 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.6 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 14.6 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 2.8 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 6.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 5.7 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 5.0 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 2.8 хувь, тээврийн бүлэг 1.7 хувь, амралт чөлөөт цаг соёлын барааны бүлэг 1.3 хувь, боловсролын үйлчилгээний бүлэг 9.9 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 10.4 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 3.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2020 оны 04 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2019-2020 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2016 -2020 оны 04 дугаар сар (өмнөх оны 12-р сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт




3.1 Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2019 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1010.6 мянган хээлтэгч малын 573.9 мянга (56.8%) нь 2020 оны эхний 04 сард төллөсөн байна. Эм хонины 66.6 хувь, эм ямааны 55.2 хувь, ингэний 30.5 хувь, үнээний 25.3 хувь, гүүний 15.2 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 99.9 хувь буюу 575.9 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 37.9 (7.0%) мянгаар илүү байна. Айраг суманд 62.4 мянга, Дэлгэрэх суманд 61.9 мянга, Даланжаргалан суманд 56.1 мянга, Алтанширээ суманд 53.2 мянга, Өргөн суманд 47.7 мянга, Иххэт суманд 44.7 мянга, Хатанбулаг суманд 42.7 мянган төл тус тус бойжсон нь нийт бойжсон төлийн 64.0 хувийг эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол 2020 оны 04 сард аймгийн хэмжээнд 314 болж, өмнөх оны мөн үеэс 90(22.0%) толгойгоор буурсан байна. Нийт хорогдсон малын 67.5 хувийг ямаа, 21.0 хувийг хонь эзэлж байна.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, жил бүрийн 04 сард



Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Улаанбадрах суманд хамгийн их буюу 1400.0 мянган төгрөг, Мандах суманд хамгийн бага буюу 900.0 мянган төгрөг, соёолон үрээ Өргөн суманд их буюу 1100.0 мянган төгрөг, Мандах суманд хамгийн бага буюу 650.0 мянган төгрөг, хязаалан гуна Алтанширээ суманд хамгийн их буюу 2000.0 мянган төгрөг, Хөвсгөл суманд хамгийн бага буюу 800.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Замын-Үүд суманд хамгийн их буюу 200.0 мянган төгрөг, Хөвсгөл суманд хамгийн бага буюу 140.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Айраг, Эрдэнэ, Замын-Үүд сумдад хамгийн их буюу 150.0 мянган төгрөг, Иххэт, Сайхандулаан сумдад хамгийн бага буюу 100.0 мянган төгрөг байна.

3.2 Аж үйлдвэр



Оны эхний 04 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 28569.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 66955.1 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 48.9 хувиар, борлуулалт 33.7 хувиар тус тус буурсан байна.

2020 оны 04 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 48.9 хувиар буурахад уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэлт өмнөх оноос 21676.5 сая төгрөгөөр, боловсруулах салбарын үйлдвэрлэлт 6183.8 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 15.0 хувийг төрийн, 85.0 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 15.0 хувь, компани 84.1 хувь, өрхийн аж ахуй 0.9 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 19.6 мян.ккалаар, сувагжуулалт 19.1 мян.м³-аар, талх 47.3 тонноор, хэрчсэн гурил 18.3 мян.тн-оор, гутал 15 ширхгээр, шохой 1850 тонноор, вакуум цонх 308.7 м²-аар, цаасан уут 5.0 мян.ширхгээр, модон эдлэл 8848.7 мян.төгрөгөөр, хайрга 5.1 мян.м³-аар тус тус илүү үйлдвэрлэгджээ.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин

Цаг уур

Температур: 4 дүгээр сарын дундаж агаарын температур Улаанбадрах, Хатанбулаг сумдад 10.0...10.3 градус, бусад сумдын нутгаар 7.6...9.4 градус, агаарын хамгийн их температур өдөртөө нийт сумдад 28...33 градус дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж / ОЖД /-тай харьцуулахад: Эрдэнэ, Замын-Үүд, Хөвсгөл сумдад ОЖД-ийн орчим, бусад сумдад ОЖД-аас дулаан байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 9...14 градус хүйтэн, өдөртөө нийт сумдад 51...54 градус дулаан байв.

Хур тунадас: 4 дүгээр сард Хөвсгөл суманд 7.5 мм, Хатанбулаг суманд 5.2 мм, Замын-Үүд суманд 4.2 мм, бусад сумдын нутгаар 0.0...2.5 мм тунадас орсон. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Хөвсгөл, Хатанбулаг, Өргөн, Сайхандулаан сумдад ОЖД-аас ахиу, Замын-Үүд, Улаанбадрах сумдад ОЖД-ийн орчим, бусад сумдын нутгаар ОЖД-аас бага тунадас орсон байна.



Салхи: Энэ сард салхины хамгийн их хурд Сайншанд, Эрдэнэ сумдад 21 м/с, Замын-Үүд, Хөвсгөл сумдад 19 м/с, Дэлгэрэх, Айраг, Мандах, Хатанбулаг сумдад секундэд 16-18 метр хүрч аюултай үзэгдлийн хэмжээнд ажиглагдсан, бусад сумдын нутгаар секундэд 12-14 метр хүрсэн. 10м/с-ээс дээш салхитай хоногийн тоо 7...19 өдөр байлаа.

Бэлчээрийн ургамал: 4 дүгээр сарын 25-ны Мандах, Дэлгэрэх сумдын нутгаар бэлчээрийн ургамал цухуйлтгүй бусад сумдын нутгаар бэлчээрийн ургамал таана, хялгана цухуйсан байна. Бэлчээрийн ургамлын дундаж өндөр 0-3 см, сумын нутгийн 4 зүгийн үнэлгээгээр Эрдэнэ, Өргөн, Замын-Үүд, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумдын нутгаар дунд зэрэг, бусад сумдын нутгаар бэлчээрийн ургамлын цухуйлт жигд бус, ургалтын байдал муу байна.

МАА-н үйлдвэрлэлд: Цаг агаарын нөхцлөөс болж малын бэлчээрлэлт саатсан тохиолдол гараагүй. Малын усан хангамж ихэнх нутгаар дунд зэрэг байлаа.

_____ о О о _____

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**
(2020 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН БАЙДЛААР)**I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд**

	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020	2020 2019
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	мянган хvн	68.2	69.6	70.5	70.6	100.1
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	410	464	421	481	114.3
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	115	128	137	114	83.2
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	295	336	284	367	129.2
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	3	1	2	7	3.5 ²
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	7.3	2.2	4.8	14.6	3.1 ²
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 733	741	673	436	64.8
- Үүнээс эмэгтэй	тоо	902	355	360	213	59.2
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	380	154	145	102	70.2
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	77	19	3	40	13.3 ²
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	77	17	2	39	19.5 ²
Улирлын чанартай ажлын байр	тоо	0	2	1	1	0.0
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	396	215	280	259	92.5
- 10000 хүнд ногдох	тоо	58	31	40	36	90.7
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	223	203	205	140	68.3
- 10000 хүнд ногдох ***	тоо	52	43	47	32	66.6
6. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	22881.6	50146.5	55875.0	28569.1	51.1
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	49191.0	72174.5	100996.9	66955.1	66.3

* - 2017,2018,2019 оны жилийн эцэст

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2019 I-IV	2020 I-IV	Өсөлт	
		Тоо		Хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	131.8	138.1	6.3	104.8
2. Ор хоног	мян.хүн	41.5	44.0	2.5	106.0
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	3.8	4.0	0.2	105.3
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	5.8	6.4	0.6	110.3
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	7.1	7.4	0.3	104.2
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	1.1	1.4	0.3	127.3
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	851	864	13	101.5
Үүнээс: нас баралт	хүн	28	17	-11	60.7
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	606	628	22	103.6
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	535	575	40	107.5
8. Амаржсан эх	хүн	421	478	57	113.5
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	2	0	-2	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	2	7	5	3.5 ²

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 04 сард

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
				хүртэл насанд аа эндсэн хүүхэд	
Тоо					
Дүн	481	0	481	7	0
Айраг					
Алтанширээ	1		1		
Даланжаргалан	1		1		
Дэлгэрэх					
Иххэт					
Мандах	1		1		
Өргөн					
Сайхандулаан					
Улаанбадрах					
Хатанбулаг	1		1		
Хөвсгөл					
Эрдэнэ	1		1		
Сайншанд	370		370	6	
Замын - Үүд	106		106	1	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 04 сард

Үзүүлэлт	2019 I-IV	2020 I-IV	Өсөлт	
	Тоо	Тоо	Тоо	Хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	280	259	-21	92.5
Вируст гепатит	0	2	2	0.0
Сүрьеэ	33	27	-6	81.8
Тэмбүү	49	33	-16	67.3
Заг хүйтэн	56	75	19	133.9
Трихоминиаз	45	34	-11	75.6
Цусан суулга	13	12	-1	92.3
Бусад	84	76	-8	90.5

Тайлбар -²-дахин их

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 04 сард

Боловсролын түвшингээр	2017 IV	2018 IV	2019 IV	2020 IV	2020 IV 2017 IV	2020 IV 2019 IV
	хүний тоо				хувь	
ДҮН	1 733	741	673	436	25.2	64.8
Үүнээс: Эмэгтэй	902	355	360	213	23.6	59.2
Магистр, доктор	7	1	1	1	14.3	0.0
Дээд боловсролтой	415	163	129	118	28.4	91.5
Тусгай дунд	178	35	43	45	25.3	104.7
Техник мэргэжлийн	163	50	44	27	16.6	61.4
Бүрэн дунд	732	440	360	203	27.7	56.4
Бүрэн бус дунд	194	31	64	35	18.0	54.7
Бага	35	4	20	2	5.7	10.0
Боловсролгүй	9	17	12	5	55.6	41.7

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 04 сард

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2019 IV	2020 IV	2019 IV	2020 IV	2019 I-IV	2020 I-IV
ДҮН	673	436	39	68	3	513
Айраг	24	19	2	0	1	21
Алтанширээ	24	7	12	0	0	9
Даланжаргалан	21	0	7	0	0	4
Дэлгэрэх	11	1	2	0	0	5
Иххэт	13	5	1	1	0	8
Мандах	5	2	0	0	0	3
Өргөн	9	0	0	0	2	4
Сайхандулаан	12	9	0	2	0	6
Улаанбадрах	3	5	0	0	0	10
Хатанбулаг	7	11	0	22	0	31
Хөвсгөл	7	4	0	0	0	5
Эрдэнэ	7	19	4	6	0	27
Сайншанд	400	240	0	30	0	286
Замын - Үүд	130	114	11	7	0	94

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 2020 оны 04 сарын эцэс

Салбарын ангилал	2019 I-IV	2020 I-IV
	Тоо	
Бүгд	165	208
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	15	2
Уул уурхай олборлох аж үйлдвэр	79	1
Боловсруулах үйлдвэрлэл		0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	2	1
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын Барилга	6	0
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн		81
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	1	5
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны	2	7
Мэдээлэл, холбоо		0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	4	1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл		1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа		14
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа,	14	20
Боловсрол	12	21
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	4	13
Урлаг, үзвэр,тоглоом наадам		7
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	26	27
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн		0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл		0

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 2020 оны 04 сарын эцэст

Үзүүлэлт	2019 I-IV	2020 I-IV
	Тоо	
Бүгд	165	208
Менежер	4	4
Мэргэжилтэн	25	67
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	27	13
Контор, үйлчилгээний ажилтан	7	11
Худалдаа, үйлчилгээний ажилтан	11	17
ХАА, ой загас агнуурын ажилтан	15	0
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний	6	14
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	16	26
Энгийн ажил мэргэжил	53	29
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	1	27

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангиллаар жил бүрийн 04 сард

Үзүүлэлт	2019 I-IV		2020 I-IV	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	тоо		тоо	
Бүгд	155	74	68	29
Менежер	2	2	0	0
Мэргэжилтэн	24	20	18	12
Техникч болон туслах дэд/мэргэжилтэн	27	10	5	4
Контор, үйлчилгээний ажилтан	7	7	5	5
Худалдаа, үйлчилгээний ажилтан	9	7	10	5
ХАА, ой загас агнуурын ажилтан	15	5	0	0
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил	6	1	5	2
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч,	15	1	16	0
Энгийн ажил мэргэжил	49	20	8	1
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	1	1	1	0

2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 2020 оны 04 сард

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар	
			Байнга	Улирал
	тоо			
Бүгд	40	9	39	1
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур				
Уул уурхай олборлолт				
Боловсруулах үйлдвэрлэл				
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент	30	2	30	
Барилга				
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ				
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	1	1		1
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа				
Мэдээлэл холбоо				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа				
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа				
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2		2	
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал				
Боловсрол	4	3	4	
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа				
Урлаг үзвэр тоглоом наадам				
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	3	3	3	
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 04 сард

Үзүүлэлт	2019 I-IV	2020 I-IV	2020 I-IV 2019 I-IV
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	12 798.4	14 142.4	110.5
Тэтгэврийн даатгалын сан	8681.5	8 902.5	102.5
Тэтгэмжийн даатгалын сан	983.4	1 009.8	102.7
Эрүүл мэндийн даатгалын сан	1307.7	2 336.3	178.7
ҮОМШӨ*-ний даатгалын сан	1432.1	1 480.7	103.4
Ажилгүйдлийн даатгалын сан	393.7	413.1	104.9
Нийгмийн даатгалын сангийн зарлага	15 688.3	19 398.2	123.6
Тэтгэврийн даатгалын сан	12130.4	14 305.3	117.9
Тэтгэмжийн даатгалын сан	920.0	1 275.0	138.6
Эрүүл мэндийн даатгалын сан	1408.8	2 405.2	170.7
ҮОМШӨ*-ний даатгалын сан	900.8	889.4	98.7
Ажилгүйдлийн даатгалын сан	328.3	523.3	159.4

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 04 сард

Үзүүлэлт	2019 I-IV	2020 I-IV	2020 I-IV 2019 I-IV
	ХҮН		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	19180	18656	97.3
Албан журмаар даатгуулагчид	15913	16084	101.1
Аж ахуй нэгж, байгууллага	8237	8364	101.5
Төсөвт байгууллага	7676	7720	100.6
Сайн дураар даатгуулагчид	3267	2572	78.7
2. Тэтгэвэр авагчдын тоо	8518	9012	105.8
Өндөр насны тэтгэвэр	6135	6561	106.9
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1274	1317	103.4
Тэжээгчээ алдсаны	501	497	99.2
Цэргийн тэтгэвэр	438	473	108.0
ҮОМШӨ*-ний	170	164	96.5
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	13 026.3	15 034.4	115.4
Өндөр насны тэтгэвэр	9 020.6	10 491.3	116.3
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1 417.2	1 661.7	117.3
Тэжээгчээ алдсаны	590.9	718.4	121.6
Цэргийн тэтгэвэр	1 096.8	1 273.6	116.1
ҮОМШӨ*-ний	900.8	889.4	98.7

Тайлбар: *-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



3.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2019 I-IV	2020 I-IV	2020 I-IV 2019 I-IV
	сая төгрөг		хувь
ДҮН	12798.4	14142.4	110.5
Айраг	232.7	228.0	98.0
Алтанширээ	79.0	95.0	120.3
Даланжаргалан	619.7	615.5	99.3
Дэлгэрэх	105.9	107.5	101.5
Иххэт	151.3	194.4	128.5
Мандах	102.1	112.2	109.9
Өргөн	416.8	289.1	69.4
Сайхандулаан	124.1	113.0	91.1
Улаанбадрах	108.5	118.5	109.2
Хатанбулаг	231.1	244.9	106.0
Хөвсгөл	102.0	112.8	110.6
Эрдэнэ	191.3	213.8	111.8
Сайншанд	6971.5	7943.3	113.9
Зүүнбаян баг	393.9	442.3	112.3
Замын-Үүд	2968.5	3312.1	111.6

3.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2019 I-IV	2020 I-IV	2020 I-IV 2019 I-IV
	сая төгрөг		хувь
ДҮН	15688.3	19398.2	123.6
Айраг	821.3	917.7	111.7
Алтанширээ	302.1	353.9	117.1
Даланжаргалан	775.9	860.0	110.8
Дэлгэрэх	343.3	408.4	119.0
Иххэт	602.2	653.9	108.6
Мандах	337.8	414.4	122.7
Өргөн	702.8	593.0	84.4
Сайхандулаан	244.1	295.5	121.1
Улаанбадрах	362.6	412.0	113.6
Хатанбулаг	657.3	710.8	108.1
Хөвсгөл	296.1	357.4	120.7
Эрдэнэ	549.8	658.5	119.8
Сайншанд	6225.0	8401.6	135.0
Зүүнбаян баг	616.5	717.4	116.4
Замын-Үүд	2851.5	3643.7	127.8



3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 04 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2020 I-IV	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2020 I-IV
	2019 I-IV	2020 I-IV	2019 I-IV	2019 I-IV	2020 I-IV	2019 I-IV
	тоо		хувь	сая төгрөг		хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	19418	18919	97.4	2855.5	2840.0	99.5
1. Халамжийн тэтгэвэр	1256	1301	103.6	800.7	932.9	116.5
Ахмад настны тэтгэвэр	65	92	141.5	42.1	64.3	152.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1191	1209	101.5	758.6	868.6	114.5
2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж	901	1046	116.1	247.7	355.6	143.6
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	853	993	116.4	231.5	336.90	20.5
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	40	48	120.0	13.4	17.1	127.6
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	6	5	83.3	2.1	1.6	74.4
Ахмад настныг гэртээ асрамжилж байгаа иргэн	2	0	0.0	0.6	0.0	0.0
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн		0			0.0	
3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	668	753	112.7	201.7	211.5	104.8
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	167	229	137.1	117.9	145.8	123.7
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	371	498	0.0	32.10	30.5	0.0
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	123		0.0	38.6	0.0	0.0
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	6	5	0.0	12.0	10.0	0.0



Хүснэгт 3.5-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2020 I-IV 2019 I-IV	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2020 I-IV 2019 I-IV
	2019 I-IV	2020 I-IV		2019 I-IV	2020 I-IV	
	тоо		хувь	мянган төгрөг	хувь	
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	1	2	0.0	1.2	2.4	0.0
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	0	18	0.0	0.0	21.6	0.0
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	0	0	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, 4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон иргэн	0	1	0.0	0.0	1.2	0.0
4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал	0	0	0.0	0	0	0.0
5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал	6540	4931	75.4	211.4	267.5	126.5
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	3299	1607	48.7	59.2	59.6	100.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	233	138	59.2	24.5	23.5	96.0
